**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 23 өдөр Дугаар А/441 Чингис хот

Иргэнд газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI. 1.57, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XX1.1.57-Д тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдагдсан 1 иргэнд 0,3 га газрыг өмчлүүлсүгэй.

2.Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 287 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай

3.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчид, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Газрын даамал /Б.Одгэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

2210 10594

Аймгийн Засаг даргын 2020 оны
..09.. дугаар сарын..23..өдрийн ..А/441..
дугаар захирамжийн хавсралт

| Д/д | Өмчлөгчийн | | | Хамтран өмчлөгчийн | | | Өмнөх Захирамжийн | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Нэр | Регистрийн дугаар | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо | Дугаар | Холбогдох хэсгийн дугаар |
| 1 | Чулуунбаатар | Мөнх-Эрдэнэ | СТ71021311 | | | | Худалдан авалттай | | |

| Д/д | Өмнөх Газрын | | Газрын | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | Байршил | Ашиглалтын зориулалт | Үнэ /Төгрөг/ |
| 1 | 221600163 | 3500 | | 3053 | 1-р баг Хангамжийн баруун талд 0-02 тоот | Гэр бүлийн хэрэгцээ | 6106000 |